

## ӨМНӨХ ҮГ

МУИС-ийн Эдийн Засгийн Сургуулиас эрхлэн гаргадаг “ЭДИЙН ЗАСАГ: онол, практик” сэтгүүлийн 21 дэх дугаарыг Та бүхэнд толилуулж байна.

Энэ дугаарт нийтлэгдэж байгаа өгүүлүүд нь макро, микро эдийн засаг, санхүү бүртгэл шинжилгээ, үйлчилгээний маркетинг, англи хэлний салбар дахь анхаарал татаж буй тулгамдсан асуудлуудыг олон талаас нь авч үзснээрээ уншигч олны сонирхолд нийцнэ гэж найдаж байна.

Нийтлэгдэж буй өгүүлэл бүр өөр өөрийн өвөрмөц оцлогтой, практик ач холбогдолтой гэж хэлж болно. Тухайлбал, Дэлхий дахинаа санхүү эдийн засгийн хямрал нүүрлээд байгаа өнөө үед манай орны эдийн засаг хямралд хир зэрэг өртсөн болон хямралаас хэрхэн гарч болох арга замын талаар “Эрэлтийг дэмжиж л хямралаас гарна” хэмээх өгүүлэлд авч үзсэн бол “Монгол улсын мэдлэгт суурилсан эдийн засагт шилжих хөгжлийн стратегийн асуудал” өгүүлэлд дэлхийн улс орнуудын хувьд мэдлэгт суурилсан эдийн засгийг бий болгох үүний тулд хүний хөгжил, нийгэм эдийн засгийнхаа өсөлтийн хэтийн төлөвийг дэлхийн болон бүс нутгийн хөгжлийн үйл явцтай нягт уялдуулах шаардлага тулгараад байгаа үед мэдлэгт суурилсан эдийн засгийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд Монгол улсын хувьд болон бусад улс орнуудад ямар түвшинд байгааг харьцуулан судалсан нь цаг үеэ олсон судалгаа болжээ. Ийм байдлаар өгүүлэл бүрийн өнгө аясыг тодорхойлж болохоор байгаа тул уншигч та өөрийн шалгуураар шүүн тунгаана биз ээ.

Академич П.Лувсандорж  
Профессор Б.Сувд

## Зохиогчид

1. **Б.Батмөнх**, Доктор(PhD) МУИС-ЭЗС-ийн Статистикийн тэнхимийн эрхлэгч, Судалгааны чиглэл: “Макро болон шилжилтийн эдийн засаг”
2. **Б.Бадамцэцэг**, Докторант, Үндэсний Статистикийн Хорооны мэргэжилтэн. Судалгааны ажлын чиглэл: Салбар хоорондын тэнцлийн үр дүн, түүнийг ашиглах нь. Бүтээл: Хэрэглээний үнийн улсын индекс тооцох аргачлал, 2008 он, Б.Бадамцэцэг, Б.Сарангэрэл, Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн үнийн индекс тооцох аргачлал, 2008 он, Б.Бадамцэцэг, Ч.Даваасүрэн
3. **Д.Чимгээ**, Доктор(PhD), МУИС-ЭЗС-ийн, Ц.Ганбат Математик-Компьютерийн тэнхимийн багш, Судалгааны сэдэв: Менежмент-Маркетингийн систем, Бүтээл: “Хөрөнгө оруулалтын шинжилгээг Excel дээр гүйцэтгэх нь”, “Монгол улс зах зээлд” 2007 он.
4. **Ж.Сарантуяа, С.Алтанцэцэг** Магистр, МУИС-ЭЗС-ийн Менежментийн тэнхимийн багш, Судалгаан сэдэв: “Компанийн засаглал, хүний нөөцийн удирдлага”, “Дээд боловсролын удирдлага, дээд боловсролын даяаршил”
5. **Dr. Troy Sternberg** .Researcher, School of Geography Oxford University
6. **Т.Элдэв-Очир**, Докторант, МУИС-ийн Орхон аймаг дахь салбар сургуулийн Санхүү эдийн засгийн тэнхимийн эрхлэгч
7. **Д.Нямаа**, Докторант, МУИС-ЭЗС-ийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш. Судалгааны чиглэл: “Нэгдсэн санхүүгийн тайлагналын онол арга, зүйн тулгамдсан асуудал. Бүтээл: Эдийн засаг: Онол практик сэтгүүл 2007/276/17, 2008. 290/18
8. **А.Дэмбэрэл, Ж.Нэргүй**, МУИС-ийн докторант, Судалгааны ажлын чиглэл: “Эдийн засгийн өсөлт, далд эдийн засаг, тогтвортой хөгжлийн асуудал” Бүтээл: “Далд эдийн засгийг тооцох арга зүйн асуудал”, “Олон улсын өртгийн зэрэгцүүлэлтийн арга зүйн асуудал”-аар илтгэл нийтлүүлсэн. “Статистикийн асуудлууд” сэтгүүлд олон улсын статистик аргачлал, шинжилгээ, судалгааны чиглэлээр мэдээлэл бэлтгэсэн.
9. **Г.Билгээ**, Докторант “Мандах Дээд” сургуулийн Нягтлан бодох бүртгэлийн тэнхимийн багш. Бүтээл: Эдийн засаг: онол практик сэтгүүл ,305/20. 2008 он
10. **Я.Отгонсүрэн**, **Äîðîð(PhD) ñáààëäààíú ñóúá:** “Байгууллагын маркетинг” Сүүлийн бүтээл: “Байгууллагын маркетингийн удирдлага” 2008 “Үйлчилгээний маркетинг” 2008 он ( 2 дахь хэвлэл)
11. **Ц.Баярмаа**, Магистр, МУИС-ЭЗС-ийн Англи хэлний тэнхимийн багш. Судалгааны чиглэл: Харьцуулсан хэл шинжлэл. Сүүлийн жилүүдэд хэвлүүлсэн бүтээл: “Англи хэлний дасгалууд”, 2005, УБ, “Англи хэлний сонсох дасгалууд”, 2005, УБ.
12. **Ч.Наранцэцэг**, Магистр, МУИС-ЭЗС-ийн Англи хэлний тэнхимийн багш, Судалгааны чиглэл: Хэл шинжлэлийн утга зүй болон гадаад хэл заах арга зүй. Бүтээл: Англи хэлний толгой үгүүдийн харьцуулсан судалгаа (Англи –монгол ) хэлээр
13. **Л.Энхмэнд**, Докторант, МУИС-ЭЗС-ийн Англи хэлний тэнхимийн багш, Сүүлийн бүтээл: ” Ыгтлан Аодох Аүртгэлийй Ыүд дñíú ÿú Àíãëë – Ыíããë Õàëëããä Õíëü” / МУИС-н хэвлэл 2007, 2008 / тус тус хэвлүүлсэн.